



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

АУДИТЫН КОД: ӨМА-2022/153/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Өмнөговь аймаг
Даланзадгад сум

2022 он

Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: С.Цэрэнбаяр

Утас: 70533552 Цахим хаяг: Tserenbayars@audit.gov.mn

Аудитын менежер: Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Аудитор Т.Хишигбат

Утас: 70533552 Цахим хаяг: Khishigbatt@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу



Нэг. Байгууллага, түүний үйл ажиллагаа

Баян-Овоо сумын Засаг даргын Тамгын газар нь төр, эдийн засаг, нийгмийн бодлогын удирдлагын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Хоёр. Санхүүгийн ба төсвийн гүйцэтгэлийн тайлангийн гол үзүүлэлтүүд

/сая төгрөгөөр/

Санхүүгийн байдлын тайлан		
	Үзүүлэлт	2021.12.31
	Эргэлтийн хөрөнгийн дүн	240.7
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	6,013.9
	Нийт хөрөнгийн дүн	6,254.6
	Нийт өр төлбөрийн дүн	
	Цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,245.0
	Өр төлбөр, цэвэр хөрөнгө/өмчийн дүн	6,245.0
Санхүүгийн үр дүнгийн тайлан		
	Үйл ажиллагааны орлогын дүн	508.7
	Үйл ажиллагааны зардлын дүн	900.8
	Үйл ажиллагааны үр дүн	-392.1
	Үйл ажиллагааны бус үр дүн	
	Үйл ажиллагааны нийт үр дүн	-399.5
Цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан		
	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,957.4
	Тайлант оны үр дүн	297.1
	Эцсийн үлдэгдэл	6,254.5
Мөнгөн гүйлгээний тайлан		
	Үйл ажиллагааны мөнгөн орлогын дүн	507.1
	Үйл ажиллагааны мөнгөн зарлагын дүн	507.1
	Үйл ажиллагааны ЦМГ	
	Хөрөнгө оруулалтын ЦМГ	
	Санхүүгийн ажиллагааны ЦМГ	
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	
Төсвийн гүйцэтгэлийн тайлан		
	Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	456.1
	Урсгал зардал	456.1
	Хөрөнгийн зардал	
	Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	456.1
	Улсын төсвөөс санхүүжих	382.3
	Төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас	73.8

Гурав. Төсвийн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн мэдээлэл



4	ТТЗ										
5	ТЕЗ										
НИЙТ		6	161.6	2	88.1			1	1.8	3	71.6

5.2 Аудитын илрүүлэлт: /Илрүүлсэн алдаа, зөрчлийн товч утга, түүнийг шийдвэрлэсэн байдал /хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал, залруулсан алдаа, төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмж//

Аудитаар нийт 161.6 сая төгрөгийн 6 алдаа зөрчил илэрснээс, 88.1 сая төгрөгийн 2 алдааг залруулж, хууль тогтоомж хэрэгжүүлж ажиллах 1.8 сая төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 71.6 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

Санхүү байдлын тайланд 18.4 сая төгрөгийн бараа материалыг тусгаагүй, Өмчийн өөрчлөлтийн тайлангийн дахин үнэлгээ баганын үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралтын дүн /хасах тэмдэг/, хуримтлагдсан үр дүн баганын нягтлан бодох бүртгэлийн бодолгын өөрчлөлтийн дүн /нэмэх тэмдэгтэй/ 69.7 сая төгрөгийн зөрүүтэй тусгасан алдааг залруулав.

Албан шаардлага:

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар тогтоосон 484,000 төгрөгийн төлбөрийн актыг бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас барагдуулсан, бага үнэтэй түргэн элэгдэх зардлаас 751,300 төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас 575,000 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Зөвлөмж:

Шилэн дансны мэдээлэлд 150 мэдээлэл оруулахаас 39 мэдээллийг хоцруулсан, үлдэх өртөггүй 22 ширхэг хөрөнгө бүртгэлтэй, төсвийн хэмнэлтийн горимыг зөрчиж 1.8 сая төгрөгийг дотоод албан томилолтын зардлаас зарцуулсан зөрчилд зөвлөмж хүргүүлсэн.



Зургаа. Аудитын санал дүгнэлт



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон 304 тоот, 3 дугаар баг,
Даланзадгад сум, Өмнөговь аймаг, 46083
Утас: (976) 7053 3539, Цахим хуудас: www.audit.mn
Цахим шуудан: umnugovi@audit.gov.mn

2022-02-22 № 115
танай _____ -ны № _____ -т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баян-Овоо сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

С.ЦЭРЭНБАЯР